

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ /2018 оны урьдчилсан гүйцэтгэл/



Улаанбаатар
2019-03-27

Мэдээлэл, хяналт
шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн Төсвийн
шинжилгээний алба


АГУУЛГА

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	3
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	3
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
2.1. Нэгдсэн төсвийн орлого	8
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага	10
2.3. Төсвийн тэнцэл	12
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	12
3.1. Гадаад худалдааны эргэлт:	12
3.2. Экспорт	14
3.3. Импорт	17
ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	20
4.1. Мөнгөний нийлүүлэлт	20
4.2. Гадаад валютын албан нөөц	22
4.3. Төлбөрийн тэнцэл	23
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	24
5.1. Хүн ам, ажил эрхлэлт	24
5.2. Ажилгүйдэл	24
ДҮГНЭЛТ	24

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 31.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.8 их наяд төгрөг буюу 13.5 хувиар өссөн байна.



Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн¹ нь 2014 онд 22.2 их наяд, 2015 онд 23.2 их наяд, 2016 онд 23.9 их наяд, 2017 онд 27.8 их наяд төгрөгт хүрсэн бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.8 их наяд төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Нэрлэсэн ДНБ-ий өсөлтөд хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 41.0 хувиар, эцсийн хэрэглээ мөн 1.5 их наяд төгрөг буюу 8.7

хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Харин 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар цэвэр экспорт өмнөх оны мөн үеэс 1.7 их наяд төгрөгөөр буурчээ.

2018 оны оны урьдчилсан гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 18.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж, эцсийн ашиглалтын аргаар тооцоолсон ДНБ-ий бодит өсөлт 6.7 хувьтай гарсан байна.



Зэрэгцүүлсэн үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн² нь 2014 оны 4 дүгээр улиралд 15.6 их наяд, 2015 онд 15.9 их наяд, 2016 онд 16.2 их наяд, 2017 оны мөн үед 17.0 их наяд төгрөг байсан бол 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 18.2 их наяд төгрөгт хүрч ДНБ-ийн бодит өсөлт 6.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ДНБ-ий бодит өсөлтөд хөрөнгийн хуримтлал 1.7 их наяд төгрөг буюу 27.2 хувиар,

¹ - эцсийн ашиглалтын аргаар оны үнээр тооцоход

² - эцсийн ашиглалтын аргаар 2010 оны зэрэгцүүлсэн үнээр тооцоолоход


эцсийн хэрэглээ 0.4 их наяд төгрөг буюу 3.2 хувиар өссөн нь нөлөөлж, харин цэвэр экспорт 0.9 их наяд төгрөгөөр буурчээ.

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 64.7 хувийг эцсийн хэрэглээ, 43.8 хувийг хөрөнгийн хуримтлал эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцсон ДНБ 3.8 их наяд төгрөгөөр нэмэгдэж, үүний дотор эцсийн хэрэглээ 1.5 их наяд төгрөг, хөрөнгийн нийт хуримтлал 3.9 их наяд төгрөгөөр өссөн бол цэвэр экспортын ашиг 1.7 их наяд төгрөгөөр буурсан байна.

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн эхний улиралд ДНБ-ий хэмжээ харьцангуй бага байснаа хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий хэмжээ 31.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.7 их наяд төгрөгөөр өсч, сүүлийн 4 жилийн дотор хамгийн өндөр үзүүлэлтэд хүрлээ. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар эцсийн хэрэглээ 4.6 их наяд төгрөг байснаа 2018 оны 4 дүгээр улиралд 5.1 их наяд төгрөг, мөн хугацаанд хөрөнгийн хуримтлал 3.5 их наяд төгрөг байсан бол 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 4.3 их наяд төгрөг болж тус тус өссөн байна. Эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлал нэмэгдсэн нь ДНБ-ий хэмжээ өсөхөд нөлөөлсөн байна.


График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/



2018 оны 4 дүгээр улиралд цэвэр экспорт -769.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөгөөр буурсан байна. Экспортын өсөлтөөс импортын өсөлт нь илүү буюу 9.3 пунктээр өндөр байна.


2018 оны 4 дүгээр улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ 8.4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд аж үйлдвэр 0.4 их наяд, үйлчилгээ 0.2 их наяд, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.2 их наяд, хөдөө аж ахуй 0.1 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

График 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/



2014-2018 оны 4 дүгээр улиралд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний хэмжээ 1.8-3.4 их наяд төгрөг байсан бол 2018 оны 4 дүгээр улиралд 3.8 их наяд төгрөг, мөн хугацаанд үйлчилгээний салбарын хэмжээ 2.9-3.1 их наяд төгрөг, харин 2018 оны 4 дүгээр улиралд 3.3 их наяд төгрөг болж тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн салбарт өсөлт гарсан нь ДНБ-ий хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар, оны үнээрх ДНБ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 38.5 хувиар, хөдөө аж ахуйн салбар 21.6 хувиар, аж үйлдвэрийн салбар 15 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 9.1 хувиар тус тус өссөн байна.



2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 40.0 хувийг үйлчилгээ, 38.2 хувийг аж үйлдвэр, 10.9 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, үлдсэн 10.9 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.

2010 оны зэрэгцүүлсэн үнээрх ДНБ 18.1 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 42.3 хувийг үйлчилгээ, 33.8 хувийг аж үйлдвэр, 13.0 хувийг хөдөө аж ахуй, 11.0 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлж байна.

1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2018 онд ДНБ-ий бодит өсөлт 6.9 хувьд хүрч, нэг хүнд ногдох ДНБ 9,929.3 мянган төгрөг болж өмнөх оноос 13.1 хувь буюу 1,151.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

График 6. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,685.4 мянган төгрөгт хүрч байсан. Харин ДНБ-ий бодит өсөлт 2011 оноос хойш тасралтгүй буурсан ч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бага зэргийн өсөлттэй байсан.

График 7. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Эдийн засгийн өсөлт 2014 оны 3 дугаар улиралд 9.1 хувьд хүрч өссөн ба 2016 оны 3 дугаар улиралд -1.4 хувь хүртэл буурсан. Харин 2016 оны 4 дүгээр улирлаас эхлэн сэргэж, эдийн засгийн бодит өсөлт тогтвортой нэмэгдэж, 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 6.9 хувьд хүрсэн байна. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өссөнөөр экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн, улсын төсвийн болон хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа зэрэг нь нөлөөлжээ.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2018 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,234.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 9,222.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 11.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2018 оны 4 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 1,847.5 тэрбум төгрөг буюу 25.0 хувиар давж биелсэн бол төсвийн нийт зарлага 817.1 тэрбум төгрөг буюу 8.1 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагдсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Хүснэгт 1.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт (+/-)	
			Зөрүү	Хувь
	2018.12			
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	7,387.4	9,234.9	1,847.5	25.0
Нийт зарлагын дүн	10,040.0	9,222.9	-817.1	-8.1
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,652.6	11.9	2,664.5	-100.4

Эх сурвалж: Сангийн яам

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,234.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 1,960.0 тэрбум төгрөг буюу 26.9 хувиар нэмэгдэж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,222.9 тэрбум төгрөгт хүрч 205.6 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2015-2018 он

Хүснэгт 2.

Үзүүлэлт	Жил бүрийн эцсийн байдлаар				Өөрчлөлт(+/-)	
					2018.12/2017.12	
	2015	2016	2017	2018	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5,981.1	5,835.0	7,274.9	9,234.9	1,960.0	26.9
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,138.0	9,495.3	9,017.3	9,222.9	205.6	2.3
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1,156.9	-3,660.3	-1,742.5	11.9	1,754.4	-100.7
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-7.3	-22.8	-10.3	0.1	0.0	

Эх сурвалж: Сангийн яам

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 11.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,754.4 тэрбум төгрөг буюу 100.7 хувиар сайжирсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 0.1 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 10.2 пунктээр сайжирсан байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,234.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 26.9 хувь буюу 1,960.0 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 25.0 хувь буюу 1,847.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.9 хувийг татварын орлого, 11.1 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 29.3 хувь буюу 1,528.1 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 7.9 хувь буюу 150.1 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 4.4 хувь буюу 116.0 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 12.3 хувь буюу 46.3 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт орлого 30.2 хувь буюу 1,561.7 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 13.6 хувь буюу 332.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Харин нийгмийн даатгалын сангийн орлого 2.5 хувь буюу 52.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлого буурсан нь Эрүүл мэндийн даатгалын санг бие даалгасантай холбоотой.

Нэгдсэн төсвийн орлогын 2018 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 3.


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	5,838.8	7,563.1	2,653.5	2,769.4	1,911.2	2,061.3	376.0	422.3
Тогтворжуулалтын сан	508.7	620.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сан	122.7	207.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5,207.3	6,735.4	2,653.5	2,769.4	1,911.2	2,061.3	376.0	422.3
Татварын орлого	3,835.0	5,431.1	1,093.5	1,155.2	1,301.4	1,451.5	376.0	422.3
Орлогын албан татвар	691.4	1,276.9	752.3	809.5	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,301.4	1,451.5	376.0	422.3
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	121.8	141.3	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,517.3	2,196.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	684.3	754.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	12.1	13.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	536.9	682.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	393.0	507.7	219.3	204.3	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,372.3	1,304.3	1,560.0	1,614.3	609.8	609.8	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	760.2	767.3	168.9	222.0	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	1.1	0.7	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	322.8	247.8	1.7	3.2	609.8	609.8	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	289.2	289.2	1,388.4	1,388.4	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 8,207.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 29.3 хувь буюу 1,859.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 26.8 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 25.4 хувийг орлогын албан татвар, 19.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 9.2 хувийг онцгой албан татвар, 8.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 8.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого бүрдүүлж байна.

График 8. Татварын орлого /тэрбум төгрөг/



Төлөвлөгөөтэй харьцуулахад бүх төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Тухайлбал: Нэгдсэн төсвийн орлогын албан татвар 44.5 хувь /642.7 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 14.3 хувь /202.2 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 16.0 хувь /19.5 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 44.8 хувь /647.1 тэрбум.төг/, онцгой албан татвар 10.2 хувь буюу /70.1 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 8.3 хувь /1.0 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 27.1 хувь /145.6 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр, хураамж 16.3 хувь /99.7 тэрбум.төг/ - өөр тус тус давж биелсэн байна.

Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 36.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 34.6 хувийг орлогын албан татвар, 10.9 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 5.4 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 3.8 хувийг онцгой албан татвар, 1.0 хувийг хөрөнгийн албан татвар тус тус эзэлжээ.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 1,892.0 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 577.9 тэрбум (35.7%), орлогын албан татвар 473.2 тэрбум (29.3%), нийгмийн даатгалын орлого 299.5 тэрбум (22.7%), онцгой албан татвар 234.7 тэрбум (45.2%), гадаад үйл ажиллагааны орлого 170.1 тэрбум (33.2%), бусад татвар, төлбөр, хураамж 125.6 тэрбум (21.4%), хөрөнгийн албан татвар 10.2 тэрбум (7.8%), тусгай зориулалтын орлого 0.7 тэрбум (5.5%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

2017 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулахад Татварын орлогын өсөлтийн 30.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 25.0 хувийг орлогын албан татвар, 15.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 12.4 хувийг онцгой албан татвар, 9.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 6.6 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 0.5 хувийг хөрөнгийн албан татвар эзэлж байна.

Татварын бус орлого 1,027.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7.1 хувь буюу 68.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төлөвлөснөөс 12.4 тэрбум төгрөг буюу 1.2 хувиар дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төсөвт байгууллагын өөрийн орлого 47.3 тэрбум, тусламжийн орлого 72.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин хувьцааны ногдол ашиг 14.2 тэрбум, хүүгийн орлого 36.0 тэрбум, торгуулийн орлого 28.3 тэрбум, бусад орлого 6.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

Татварын бус орлогын 96.3 хувийг нийтлэг татварын бус орлого, 3.7 хувийг тусламжийн орлого эзэлсэн байна. Нийтлэг татварын бус орлогын 31.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.4 хувийг газрын тосны орлого, 16.9 хувийг навигацгийн орлого, 9.1 хувийг бусад орлого, 7.8 хувийг хувьцааны ногдол ашиг, 6.5 хувийг торгуулийн орлого, 5.1 хувийг хүүгийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого, тус тус эзэлж байна.



2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 10,040.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 91.9 хувийг ашиглаж, 817.1 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 576.4 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 223.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сан 29.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 5.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс хэтэрч зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зардал 5.2 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 76.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол орон нутгийн төсвийн зардал 279.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөө биелэлт, %	Өөрчлөлт 2018.12/2017.12	
	2018.12	2017.12	2018.12		Төлөв/Гүйцэт	Дүн	Хувь
	1	2	3		(3:1)	(2-3)	(2-3)/3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,040.0	9,017.3	9,222.9		91.9	205.6	2.3
НИЙТ ЗАРЛАГА	9,751.3	8,701.3	8,955.8		91.8	254.5	2.9
УРСГАЛ ЗАРДАЛ	7,690.2	7,043.2	7,348.0		95.6	304.8	4.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,469.6	3,141.4	3,316.4		95.6	175.0	5.6
ХҮҮ	1,150.70	1,156.50	1,046.90		91.0	-109.6	-9.5
ТАТААС	245.5	260.6	228.2		93.0	-32.4	-12.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,824.40	2,484.60	2,756.60		97.6	272.0	10.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,061.10	1,658.10	1,607.8		78.0	-50.3	-3.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	288.7	316	267.1		92.5	-48.9	-15.5

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 2.3 хувь буюу 205.6 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 15.5 хувь буюу 48.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 3.0 хувь буюу 50.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан ч урсгал зардал 4.3 хувь буюу 304.8 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил, үйлчилгээний зардал 5.6 хувь буюу 174.9 тэрбум, урсгал шилжүүлэг 10.9 хувь буюу 272.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол зээлийн үйлчилгээний төлбөр 9.5 хувь буюу 109.6 тэрбум, татаас 12.5 хувь буюу 32.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 109.6 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 103.9 тэрбум төгрөгөөр буюу 9.0 хувиар тус тус бага байгаа нь тайлант хугацаанд улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 79.7 хувь буюу 7,348.0 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 45.1 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 14.2 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.1 хувийг татаас, 37.5 хувийг урсгал шилжүүлэг эзэлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 304.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд: татаас 32.5 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 109.6 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал шилжүүлэг 272.0 тэрбум, бараа үйлчилгээний зардал 174.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 11.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.1 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарсан байна.

Төсвийн тэнцэл

Хүснэгт 5.

Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар			Төлөв.	Гүйцэт.	Өөрчлөлт(+/-)	
	2015	2016	2017			2018.12/2017.12	
				2018		Дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1,156.9	-3,660.3	-1,742.5	-2,652.6	11.9	-2,664.7	0.2
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-7.3	-22.8	-10.3	-	0.1	-	-

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 399.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 53.0 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 247.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 110.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 26.9 хувиар өсч, харин нийт зарлага 2.3 хувиар нэмэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг өнгөрсөн оны мөн үеэс 1,754.4 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн хэмжээнээс 2,664.5 тэрбум төгрөгөөр буурч эерэг тэнцэл гарахад нөлөөлсөн байна.

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 280.1 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,767.7 тэрбум төгрөгийг, гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, 964.9 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авчээ. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт:

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 22.3 хувь буюу 2,348.9 сая ам.доллараар нэмэгдэж 12,886.8 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улс дэлхийн 156 оронтой гадаад худалдаа хийсэн байна. Экспорт 811.2 сая ам.доллар буюу 13.1 хувиар, импорт 1,537.7 сая ам.доллар буюу 35.5 хувиар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн дөрвөн жил дараалан ашигтай гарсан байна.

Гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 6.

/сая ам.доллар/


Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар				Өөрчлөлт	
	2015	2016	2017	2018	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	8,466.8	8,274.5	10,537.9	12,886.8	2,348.9	22.3
- Экспорт	4,669.3	4,916.3	6,200.6	7,011.8	811.2	13.1
- Импорт	3,797.5	3,358.1	4,337.3	5,875.0	1,537.7	35.5
Тэнцэл	871.8	1,558.2	1,863.3	1,136.7	(726.6)	(39.0)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **1,136.7** сая ам.долларын ашигтай гарсан. Өмнөх оноос **726.6** сая ам.доллар буюу **39.0** хувиар буурсанд импортын өсөлт нөлөөлсөн байна.

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2012.01-2018.12)-аар тооцон үзэв. 2012-2016 онд импорт буурсаар ирсэн бөгөөд 2016 оны сүүлчийн хагас жилээс импортын худалдаа эргэн өсч байна. Харин экспортын худалдаа 2017 оны 4 дүгээр улиралд огцом буурч 2018 оны 1 дүгээр улирлын дунд үеэс дахин өсч байна.

График 10. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,501.1 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч, өнгөрсөн оны мөн үеэс 548.6 сая ам.доллараар буурсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 66.3 хувь буюу 8,537.9 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 13.9 хувь буюу 1,796.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн. Үүний дотор БНХАУ нь экспортын 93.3 хувь /6,542.8 сая ам.доллар/, импортын 34.0 хувь /1,995.0 сая ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ нь экспортын 1.2 хувь /85.9 сая ам.доллар/, импортын 29.1 хувь /1,710.3 сая ам.доллар/-ийг эзэлж байна. 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 80.2 хувь, экспортын 94.5 хувь, импортын 63.1 хувийг хөрш орнууд эзэлж байна.

Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 7.

/сая ам.доллар/

Улс	Төрөл	Жилийн эцсийн байдлаар				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2016	2017	2018	2018.12/2017.12	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	66.3	4,962.8	6,737.1	8,537.9	1,800.7	26.7
	Экспорт	93.3	3,901.6	5,307.4	6,542.8	1,235.4	23.3
	Импорт	34.0	1,061.2	1,429.7	1,995.0	565.3	39.5
	Тэнцэл		2,840.5	3,877.7	4,547.8	670.1	17.3
ОХУ	Нийт эргэлт	13.9	936.2	1,284.9	1,796.3	511.4	39.8
	Экспорт	1.2	55.8	67.7	85.9	18.3	27.0
	Импорт	29.1	880.4	1,217.3	1,710.3	493.1	40.5
	Тэнцэл		-824.6	-1,149.6	-1,624.4	-474.8	41.3
Бусад	Нийт эргэлт	19.8	2,375.5	2,515.9	2,552.7	36.8	1.5
	Экспорт	5.5	958.9	825.5	383.0	-442.5	-53.6
	Импорт	36.9	1,416.6	1,690.4	2,169.7	479.3	28.4
	Тэнцэл		-457.6	-864.9	-1,786.7	-921.8	106.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нь БНХАУ-тай хийх экспортын худалдааг 23.3 хувь буюу 1,235.4 сая ам.доллараар нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Дотоодын гол нэр төрлийн уул, уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрчимжсэн, нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ өссөн, суудлын болон ачааны автомашины импортын тоо хэмжээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан ОХУ-тай хийсэн импортын худалдаа 493.1 сая ам.доллар буюу 40.5 хувиар, БНХАУ-тай хийсэн импорт 565.3 сая ам.доллар буюу 39.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсын гадаад худалдаа нь БНХАУ-тай ашигтай, харин ОХУ-тай алдагдалтай байна.

3.2. Экспорт

Экспортын худалдаа 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7,011.8 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 811.2 сая ам.доллар буюу 13.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1,136.6 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 6,070.3 сая ам.долларт хүрч өмнөх оноос 1,136.6 сая ам.доллар буюу 23.0 хувиар өссөн бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 941.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 325.5 сая ам.доллар буюу 26.0 хувиар буурсан байна. Нийт экспортын 86.6 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 13.4 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт

Хүснэгт 8.


/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жилийн эцэст /сая ам.дол/			Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2016	2017	2018	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүн экспорт	3,484.1	4,933.7	6,070.3	1,136.6	23.0	86.6
Эрдсээс бусад бүтээгдэхүүн экспорт	1,432.3	1,266.9	941.4	(325.5)	(26.0)	13.4



Нийт экспорт	4,916.3	6,200.6	7,011.8	811.2	13.1	100.0
---------------------	----------------	----------------	----------------	--------------	-------------	--------------


Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын орлогын 68.7 хувийг зэсийн баяжмал болон нүүрс гэсэн 2 бүтээгдэхүүн дангаар бүрдүүлж байна.



Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр болон боловсруулаагүй газрын тосны экспортын өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр харууллаа. Үүнд:





2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмал, нүүрс, төмрийн баяжмал, боловсруулаагүй нефть болон алт, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн нийт экспортын орлогын 84.0 хувийг эзэлж байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт

Хүснэгт 9.

№	Төрөл	Хэмжих нэр	2013.12	2014.12	2015.12	2016.12	2017.12	2018.12
1	Зэсийн баяжмал	мян.тн	649.8	1,379.0	1,477.8	1,562.0	1,447.22	1,436.7
		сая ам.дол	949.0	2,574.7	2,280.1	1,607.8	1,613.1	2,012.2
2	Нүүрс	сая.тн	18.4	19.5	14.5	25.8	33.4	36.3
		сая ам.дол	1,122.0	849.0	555.9	973.1	2,267.6	2,802.5
3	Төмрийн хүдэр	сая.тн	6.7	6.3	5.1	6.1	6.3	7.4
		сая ам.дол	654.3	446.4	227.2	249.9	313.4	342.2
4	Түүхий газрын тос	сая.баррел	5.2	6.9	8.1	8.0	7.5	6.2
		сая ам.дол	515.5	634.6	387.2	337.2	374.1	392.0
5	Алт	тн	7.6	10.	11.3	19.2	14.55	3.4
		сая ам.дол	309.8	405.2	420.6	758.4	595.4	144.5
6	Цайрын баяжмал	мян.тн	130.9	99.4	84.1	126.0	118.22	123.9
		сая ам.дол	119.1	113.2	101.7	145.4	180.8	197.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр эрдсийн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс 1,136.6 сая ам.доллар буюу 23.0 хувиар өсөхөд дараахь хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- **Нүүрс:** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 36.3 сая тонн нүүрс экспортлож 2,802.5 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 534.9 сая ам.доллараар буюу 23.6 хувиар өссөн байна. Нүүрсний биет хэмжээ 8.6 хувь буюу 2.9 сая тонноор өссөн бөгөөд хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өссөн нь нүүрсний экспортын орлогыг өсөхөд голлон нөлөөлжээ.
- **Зэсийн баяжмал:** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 24.7 хувь буюу 399.1 сая ам.доллараар нэмэгдэж 2,012.2 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 1,436.7 мянган тонн болж өнгөрсөн оны

мөн үеэс 0.7 хувь буюу 10.5 мянган тонноор буурсан ч хилийн дундаж үнэ нь 25.7 хувиар нэмэгдсэн нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

- **Алт:** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.4 тонн алт экспортлож 144.5 сая ам.долларын экспортын орлого олжээ. Алтны экспортын орлого өмнөх оны мөн үеэс 450.9 сая ам.доллараар буурсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад алтны экспортын тоо хэмжээ 3.4 тонн болж 76.7 хувиар буурсан ба экспортын дундаж үнэ 2.9 хувиар өссөн боловч алтны экспортын орлого буурчээ.
- **Төмрийн хүдэр:** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 7.4 сая тоннд хүрч 342.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 9.2 хувь буюу 28.8 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 19.0 хувь буюу 1.2 сая тонноор нэмэгдсэн нь нөлөөлсөн боловч хилийн үнэ 8.2 хувиар буурсан байна.
- **Боловсруулаагүй нефть:** Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 17.9 сая ам.доллараар нэмэгдэж, 392.0 сая ам.долларт хүрчээ. Боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 17.6 хувь буюу 1.3 сая баррель хэмжээгээр буурсан хэдий ч, хилийн дундаж үнэ 27.2 хувиар өссөн нь экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлжээ.

Нийт экспортын 40.0 хувийг нүүрс, 28.7 хувийг зэсийн баяжмал, 5.6 хувийг боловсруулаагүй нефть, 4.9 хувийг төмрийн баяжмал, 2.8 хувийг цайрын баяжмал, 2.7 хувийг жоншны хүдэр, 2.1 хувийг алт эзэлсэн байна.

3.3. Импорт

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр импортын хэмжээ 5,875.0 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,537.7 сая ам.доллар буюу 35.5 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,325.8** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **339.9** сая ам.доллар буюу 34.5 хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **4,549.3** сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс **1,197.8** сая ам.доллар буюу **35.7** хувиар тус тус өссөн байна.

Нийт импортын **22.6** хувийг нь эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.4** хувийг нь эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт

Хүснэгт 10.

Үзүүлэлт	Жилийн эцсийн байдлаар				/сая ам.доллар/		Нийт экспортод эзлэх хувь
					Өөрчлөлт		
	2015	2016	2017	2018	2018.12/2017.12	Сая ам.дол	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	936.4	724.3	985.9	1,325.8	339.9	34.5	22.6
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,861.1	2,633.9	3,351.4	4,549.3	1,197.9	35.7	77.4
Нийт импорт	3,797.5	3,358.2	4,337.3	5,875.1	1,537.8	35.5	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр импортын 41.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 28.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 13.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 19.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна. Бүтээгдэхүүний импортод эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.

Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

Хүснэгт 11.

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	Жилийн эцсийн гүйцэтгэл						Өөрчлөлт 2018/2017
	2016		2017		2018		
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Хэрэглээ	1,159.0	34.0	1,286.0	30.0	1,643.0	28.0	357.0
- Түргэн эдэлгээтэй	652.0	19.0	733.0	17.0	864.0	15.0	131.0
- Удаан эдэлгээтэй	507.0	15.0	553.0	13.0	779.0	13.0	226.0
Хөрөнгө оруулалт	1,153.0	34.0	1,701.0	39.0	2,396.0	41.0	695.0
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	685.0	20.0	1,077.0	25.0	1,512.0	26.0	435.0
- Барилгын материал	283.0	8.0	441.0	10.0	648.0	11.0	207.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	185.0	6.0	183.0	4.0	236.0	4.0	53.0
Аж үйлдвэрлэлийн орц	508.0	15.0	552.0	13.0	717.0	12.0	165.0
- Цахилгаан эрчим хүч	124.0	4.0	136.0	3.0	143.0	2.0	7.0
Нефтийн бүтээгдэхүүн	533.0	16.0	789.0	18.0	1,113.0	19.0	324.0
- Дизель	257.0	8.0	428.0	10.0	577.0	10.0	149.0
- АИ-92, 95	165.0	5.0	211.0	5.0	264.0	4.0	53.0
- А80 ба бусад	111.0	3.0	150.0	3.0	272.0	5.0	122.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 695.0 сая ам.доллар, аж үйлдвэрийн орц 165.0 сая ам.доллар, хэрэглээний бүтээгдэхүүн 357.0 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүн 324.0 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал машин, тоног төхөөрөмж, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл 435.0 сая ам.доллар, дизель 149.0 сая ам.доллар, АИ-92, 95 53.0 сая ам.доллар, А80 ба бусад 122.0 сая ам.доллар, түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 131.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 226.0 сая ам.доллар, барилгын материал 207.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 2017 оны мөн үетэй харьцуулахад 357.0 сая ам.доллараар нэмэгдэхэд удаан эдэлгээтэй бүтээгдэхүүнээс суудлын авто машин, түүний сэлбэгийн импорт 171.0 сая ам.доллар, түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүнээс хүнсний бүтээгдэхүүн 86.0 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 694.0 сая ам.доллараар өсөхөд машин, механизм, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийн бүтээгдэхүүн 435.0 сая ам.доллар, барилгын материал 207.0 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын бусад бараа 53.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өмнөх оны мөн үеэс 323.0 сая ам.доллараар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нөлөөлжээ. Дизель түлшний импорт 149.0 сая ам.доллар, бензин 175.0 сая ам.доллараар нэмэгджээ.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын биет хэмжээ
Хүснэгт 12.

Барааны нэр	Хэмжих нэгж	12 дугаар сар				Өөрчлөлт 2018.12/2017.12	
		2015	2016	2017	2018	Зөрүү	Хувь
Суудлын авто машин	мян.ш	37.1	37.7	48.9	64.0	15.2	31.0
Ачааны автомашин	мян.ш	7.7	6.8	14.2	22.3	8.1	57.2
Дизель түлш	мян.тн	655.0	548.1	805.3	848.8	43.5	5.4
Автобензин	мян.тн	433.5	384.7	410.9	435.5	24.6	6.0
Цахилгаан эрчим хүч	сая.квт.ц	1,384.8	1,420.2	1,574.3	1,665.7	91.4	5.8
Импортын архи, дарс	сая.л	18.1	19.4	9.6	11.2	1.7	17.4
Импортын пиво	сая.л	15.9	16.7	6.4	7.4	1.0	15.2
Янжуур	сая.ш	2,026.2	2,247.1	2,901.7	2,550.3	(351.4)	(12.1)
Цагаан будаа	мян.тн	24.5	26.6	34.3	44.1	9.8	28.7
Улаан буудай	мян.тн	21.1	158.5	13.6	232.0	218.4	1,608.
Элсэн чихэр	мян.тн	39.3	50.0	50.1	66.3	16.2	32.5
Гахайн мах, өөх	мян.тн	5.0	4.3	6.0	6.5	0.4	7.0
Шинэ дугуй	мян.ш	103.5	145.7	174.2	236.7	62.5	35.9
Бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор	ш	432.0	367.0	816.0	1,234.0	418.0	51.2
Компьютер, түүний бүрдэл хэсэг	мян.ш	86.1	86.7	76.9	97.0	20.1	26.1
Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	мян.ш	517.7	462.4	733.6	747.0	13.4	1.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний импортын дүн
Хүснэгт 13.

Барааны төрөл	12 дугаар сар				Өөрчлөлт 2018.12/2017.12	
	2015	2016	2017	2018	Зөрүү	Хувь
Суудлын авто машин	210.0	219.7	260.4	407.8	147.5	56.6
Ачааны автомашин	49.9	46.5	191.3	283.7	92.5	48.3
Дизель түлш	376.7	254.8	427.9	576.7	148.8	34.8
Автобензин	274.0	192.7	243.7	308.6	64.9	26.6
Цахилгаан эрчим хүч	129.2	125.4	136.0	142.5	6.5	4.8
Импортын архи, дарс	18.0	18.0	20.4	25.1	4.9	23.4
Импортын пиво	7.2	6.9	3.8	4.8	1.0	25.9
Янжуур	52.2	50.0	56.7	53.7	(3.0)	(5.3)
Цагаан будаа	15.8	16.0	20.6	26.1	5.5	26.5
Улаан буудай	4.5	33.3	2.7	44.3	41.7	1,564.7
Элсэн чихэр	18.4	25.5	25.2	30.7	5.5	22.0
Гахайн мах, өөх	6.6	6.8	9.0	10.3	1.3	14.8
Шинэ дугуй	32.0	36.4	53.3	64.2	10.9	20.5
Бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор	45.0	31.0	87.3	133.2	45.9	52.6
Компьютер, түүний бүрдэл хэсэг	45.7	29.2	28.3	42.5	14.2	50.3
Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	14.1	11.1	23.2	30.1	6.8	29.3
Нийт импортод эзлэх хувь	34.2	32.9	36.7	37.2		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 19,474.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,613.5 тэрбум төгрөг буюу 22.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 2,408.5 тэрбум төгрөг буюу 18.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. Төгрөгийн хадгаламж 1,534.3 тэрбум төгрөг буюу 17.8 хувь, валютын хадгаламж 487.6 тэрбум төгрөг буюу 19.3 хувь, валютын харилцах 386.6 тэрбум төгрөг буюу 20.6 хувиар тус тус өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

Хүснэгт 14. /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2018/2017	
	2015	2016	2017	2018	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	10,049.0	12,158.5	15,861.2	19,474.7	3,613.5	22.8
Бараг мөнгө	8,363.6	10,010.8	13,035.2	15,443.7	2,408.5	18.5
- Төгрөгийн хадгаламж	5,434.0	5,789.9	8,622.0	10,156.2	1,534.3	17.8
- Валютын хадгаламж	1,947.8	2,789.7	2,531.9	3,019.5	487.6	19.3
- Валютын харилцах	981.7	1,431.2	1,881.3	2,268.0	386.6	20.6
M1 мөнгө	1,685.4	2,147.7	2,826.0	4,031.0	1,205.0	42.6
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	706.7	823.6	906.4	968.6	62.2	6.9

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 17.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.6 их наяд төгрөг буюу 26.5 хувиар нэмэгдсэн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл

Хүснэгт 15. /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн эцсийн гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2018.12/2017.12	
	2015	2016	2017	2018	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	11,706.6	12,422.7	13,615.1	17,225.7	3,610.6	26.5
- Хэвийн зээл	9,982.8	10,466.7	11,638.8	14,592.4	2,953.6	25.4
- Хугацаа хэтэрсэн зээл	854.0	904.3	823.3	848.8	25.4	3.1
- Чанаргүй зээл	869.8	1,051.7	1,153.0	1,784.5	631.5	54.8
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	7.4	8.5	8.5	10.4	1.9	22.3
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	7.3	7.3	6.0	4.9	-1.1	(18.5)

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 848.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 25.4 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувь, хэвийн зээлийн 5.8 хувийг тус тус эзэлжээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,784.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 631.5 тэрбум төгрөг

буюу 54.8 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.4 хувь, хэвийн зээлийн 12.2 хувийг эзэлсэн байна. Зээлийн эргэн төлөлт удааширсан, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл нэмэгдэж байгаа нь банкны тогтолцооны хувьд ихээхэн эрсдлийг бий болгохоор байна. Нийт чанаргүй зээлийн 85.1 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээл, 14.3 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээл 631.5 тэрбум төгрөг буюу 54.8 хувиар өссөн бөгөөд энэ өсөлтийн 93.3 хувь буюу 589.5 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж, 6.5 хувь буюу 40.8 тэрбум төгрөгийг иргэдийн зээл эзэлсэн байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2018 оны жилийн эцэст нийт **667.3** сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **360.2** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 75.3 хувиар буурсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2018 оны жилийн эцэст **149.8** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 80.0 хувиар буюу **600.1** тэрбум төгрөгөөр буурсан байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2018 оны жилийн эцэст **20,076.5** болж, өмнөх оны мөн үеэс 2,032.0 нэгж буюу 9.2 хувиар буурсан байна.

Валютын ханш: 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,637.35 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.1 хувиар, оны эхнээс 8.7 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 383.03 төгрөг болж, өмнөх сараас 3.0 хувиар, оны эхнээс 1.5 хувиар тус тус суларсан байна.



Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн улсын индекс 2018 оны жилийн эцэст 8.1 хувь болж өмнөх сартай ижил түвшинд хэвээр байгаа ба өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр өссөн байна.



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц

Нийт албан нөөцийн хэмжээ 2018 оны жилийн эцсийн байдлаар 3,541.6 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 533.5 сая ам.доллар буюу 1.2 дахин нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2018 оны жилийн эцсийн байдлаар 3,541.6 сая ам.доллар буюу сүүлийн 12 сарын дундажаар тооцсон импортын 7.2 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ өссөн, мөн гадаад валютын албан нөөц өссөн нь импортын сарын хэрэгцээг хангах түвшинг нэмэгдүүлжээ.

Гадаад валютын албан нөөц ба импорт

Хүснэгт 16.

		/сая ам.дол/					
№	Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
1	Нийт импорт	6,357.8	5,236.7	3,797.5	3,358.1	4,337.3	5,875.0
2	Гадаад валютын нийт нөөц	2,248.0	1,649.9	1,323.1	1,296.3	3,008.1	3,541.6
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	4.2	3.8	4.2	4.6	8.3	7.2

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2018 оны жилийн эцсийн байдлаар 21.9 тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.9 тонноор өссөн байна.



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл нь урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 705.0 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн тэнцэл 900.8 сая ам.долларын ашигтай гарснаар төлбөрийн тэнцэл 334.1 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оныхоос 923.9 сая ам.доллараар буурч, төлбөрийн тэнцэл муудсан байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар урсгал данс 734.1 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 70.6 сая ам.доллар гарсан бол харин бараа ба үйлчилгээ 423.8 сая ам.долларын, цэвэр орлого 380.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 144.3 сая ам.доллараар буурсан байна.

Урсгал дансны алдагдалд цэвэр орлого өмнөх оноос 142.4 сая ам.доллараар буурсан ч бараа, үйлчилгээний худалдааны тэнцлийн алдагдал 305.4 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

2018 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн дансны тэнцэл 900.8 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 781.8 сая ам.доллараар буурсан байна. Төлбөрийн тэнцэл 334.1 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 923.9 сая ам.доллараар ашгийн хэмжээ буурсан байна.

Төлбөрийн тэнцэл, 2016.12 - 2018.12

Хүснэгт 17.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
	2016.12	2017.12	2018.12	2017/2016	2018/2017
Урсгал данс	16.6	-589.9	-734.1	-606.5	-144.3
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	243.7	-118.4	-423.8	-362.2	-305.4
В. Орлого	-262.9	-523.3	-380.9	-260.4	142.4
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	35.8	51.9	70.6	16.1	18.7
Хөрөнгийн данс	20.6	21.0	29.1	0.4	8.1
I. Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	37.2	-568.9	-705.0	-606.1	-136.2
Санхүүгийн данс	-153.3	-1,682.6	-900.8	-1,529.3	781.8
II. Санхүүгийн дансны тэнцэл	-153.3	-1,682.6	-900.8	-1,529.3	781.8
III. Алдаа болон орхигдуулга	23.5	144.3	138.3	120.8	-6.0
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	213.9	1,258.0	334.1	1,044.1	-923.9

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хүн ам, ажил эрхлэлт

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны жилийн эцэст 36.2 мянган хүн болж, үүнээс 25.0 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.2 мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 1.9 хувь буюу 486 хүнээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 48.4 хувь нь бүрэн дунд, 29.7 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 6.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.3 хувь нь суурь, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 2.2 хувь нь бага, 1.1 хувь нь магистр, доктор, 1.2 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 56.7 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,345.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 22.0 мянган хүнээр буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 61.9 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан бол ажилгүйдлийн түвшин 6.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр буурсан байна.

Харин 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 827.8 мянга болж, өмнөх оноос 5.1 мянган иргэдээр өссөн байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын 267.1 мянга нь тэтгэвэрийн насны хүмүүс, 244.9 мянга нь суралцагчид, 118.1 мянга нь хүүхэд асарсан, 73.0 мянга нь гэрийн ажилтай, 59.6 мянга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үлдэх 65.1 мянга нь өвчтэй, өвчтөн ба өндөр настан асарсан, ажил хийхийг хүсээгүй болон бусад шалтгаантай иргэд байна.

5.2. Ажилгүйдэл

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.0 пунктээр буур, өмнөх улирлаас 0.9 пунктээр өссөн байна. Харин 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 2.2 пунктээр буурчээ. Ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч, макро эдийн засагт сэргэлт гарч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн бизнесийн идэвхжил сайжирч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь ажлын байр шинээр бий болох, ажилгүйдлийн түвшин буурах нөхцлийг бүрдүүлэх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

1. Эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлтүүд

- **Эдийн засагт бодит өсөлт гарч байна.** Эдийн засгийн бодит өсөлт 2017 онд 5.1 хувьтай байсан бол 2018 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын

- өсөлт нөлөөлсөн байна. Нөгөө талдаа эцсийн хэрэглээ болон хөрөнгийн хуримтлалд өсөлт гарсан нь нөлөөлжээ.
- **Төсвийн орлого нэмэгдэж байна.** Өмнөх жилүүдэд буюу 2016 оны жилийн эцэст 5.8 их наяд төгрөг байсан нэгдсэн төсвийн орлого 2017 онд 7.9 их наяд болж өссөн бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс **1,960.0** тэрбум төгрөгөөр, төлөвлөгөөнөөс **26.9** хувиар тус тус нэмэгдсэн байна. Улсын болон, орон нутгийн төсвийн орлого тус тус давж биелсэн үзүүлэлттэй байна.
 - **Төсвийн орлогын өсөлт, зарлагын хэмнэлтийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурч, тэнцэл сайжирч, ашигтай гарсан байна.** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь 0.1 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 10.2 пунктээр бага гарч, төсвийн тэнцэл сайжирлаа.
 - **Гадаад худалдааны үзүүлэлтүүд сайжирч, экспорт болон импортын худалдаа нэмэгдэж, гадаад худалдаа ашигтай үзүүлэлттэй гарчээ.** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр экспорт 7.0 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 811.2 сая ам.доллар буюу 13.1 хувиар, импорт 5.8 тэрбум ам.долларт хүрч, 1.5 тэрбум ам.доллар буюу 35.5 хувиар тус тус өслөө. Экспортын өсөлтийн дүнгээс импортын өсөлт илүү байгаа хэдий ч гадаад худалдааны тэнцэл 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Импортын өсөлтөд уул, уурхайн үйлдвэрлэл, түүнийг дагасан үйлчилгээний өсөлт, ялангуяа машин, механизм, тоног төхөөрөмжийн эд анги, нефтийн бүтээгдэхүүний импорт, аж үйлдвэрийн орц, барилгын материалын импорт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
 - **Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 52.5 хувийг нь төгрөгийн хадгаламж, 27.1 хувийг нь валютын хадгаламж, харилцахын өсөлт эзэлж байна.
 - **Гадаад валютын албан нөөц тогтвортой өсч, импортын хэрэгцээг хангах түвшин нэмэгдэж байна.** Гадаад валютын албан нөөц өмнөх жилүүдэд тасралтгүй буурч 2016 оны 9 сард 1,092.4 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2017 оны эхний улирлаас хойш эргэн өсч 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3,541.6 сая ам.доллар болсон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад валютын албан нөөц 533.5 сая ам.доллараар өссөн байна.
 - **Ажилгүйдлийн түвшин буурсан байна.** 2018 оны жилийн эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр буурч, өмнөх улирлаас 0.9 пунктээр өссөн байна. Ажилгүйдлийн түвшин буурч байгаа нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн бизнесийн идэвхжил сайжирч ажлын байр шинээр бий болж байгаа зэрэгтэй холбоотой байна. Цаашид ажилгүйдлийн түвшинг тогтвортой бууруулахад чиглэсэн томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.
 - **Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны идэвх багассан.** Үнэт цаасны арилжаа хумигдаж, гүйлгээ 360.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 75.6 хувиар өсчээ.
 - **Зээлийн үйлчилгээний төлбөр буурсан байна.** Нэгдсэн төсвийн зээлийн үйлчилгээний төлбөр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,046.9 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 11.3 хувь, нийт зарлагын мөн 11.4 хувийг эзэлж байна. 2013 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4 дахин өссөн байна. Харин 2017 оны мөн үетэй харьцуулахад 109.6 тэрбум төгрөгөөр буюу 9.5 хувиар буурсан байна. Зээлийн үйлчилгээний төлбөр тайлант хугацааны төлөвлөсөн

дүнгээс 103.9 тэрбум төгрөгөөр бага байгаа нь улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.



- **Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа.** Төлбөрийн тэнцэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 334.1 сая ам.долларын ашигтай гарлаа. Үүнд урсгал ба хөрөнгийн данс 2018 оны 4 дүгээр улиралд 705 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 901 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 334 сая ам.долларын ашигтай гарсан. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 138 сая ам.доллар байна.

2. Нийгэм, эдийн засагт тулгамдаж буй зарим асуудал

- **Нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляци оны эцсээр нэмэгдлээ.** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр инфляцийн түвшин 8.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр өссөн байна. Тайлант улиралд хүнс болон төрийн зохицуулалттай барааны үнэ төсөөллөөс бага байв. Эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж байгаа боловч нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт сүүлийн саруудад огцом нэмэгдлээ. Мөнгөний бодлогын хүүг 11 дүгээр сард өсгөсөн нь УИХ-аас баталсан Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийг 2018-2020 онд жилийн 8 орчим хувьд тогтворжуулах зорилттой нийцсэн байна.
- **Валютын ханш чангарсан байна.** 2018 оны жилийн эцсийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш нь 2,637.4 төгрөг болж, оны эхнээс 8.7 хувиар суларсан бол төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 383.0 төгрөг болж, оны эхнээс 1.5 хувиар мөн суларсан байна.
- **Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл өссөн байна.** 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн зээл өнгөрсөн оны мөн үеэс 25.4 тэрбум төгрөгөөр өсч 848.8 тэрбум төгрөг болсон бол чанаргүй зээл 631.5 тэрбум төгрөгөөр өсч 1,784.5 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.4 хувийг эзэлж, эрсдэл өндөр хэвээр байна. Чанаргүй зээлийн 85.1 хувийг хувийн хэвшил, 14.3 хувийг иргэдийн зээл эзэлсэн байна.
- **Хөрш орны эдийн засгаас хамааралтай, түүхий эдэд суурилсан экспортын бүтэцтэй хэвээр байна.** Нийт экспортын 84 хувийг баяжмал, хүдэр, түүхий эд зонхилж байна. Нийт гадаад худалдааны эргэлтэд хөрш орнууд дийлэнх хувийг эзэлж байгаа боловч нийт экспортын 2.5 хувийг ОХУ-ын экспорт эзэлж байгааг цаашид нэмэгдүүлэх боломжуудыг судлах хэрэгтэй юм. Мөн эдийн засаг, түүний дотор экспортын бүтээгдэхүүний төрөлжилтөд анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

---oOo---